

Наманчлал

АСУУДАЛ 1

Би үүнийг наманчлах ёстой эсэхийг мэдэхгүй байна.

- Та Мозая 26-аас эсвэл бусад судраас энэ асуудалд тусалж болох ямар судар, зарчмыг хуваалцаж болох вэ?

Алма өөрөө өмнө нь ноцтой нүгэл үйлдэж, түүнийгээ наманчилж, Аврагч Есүс Христээр дамжуулан өршөөл хүлээн авсныг эргэн сана (Мозая 11:5–7; 18:1–3; 26:15, 20-ийг үзнэ үү).

- Алма ийм асуудалтай хүнтэй юу хуваалцаж магадгүй гэж та бодож байна вэ?

Наманчлалаар дамжуулан Аврагч Есүс Христэд хандахдаа та эсвэл таны мэддэг хүмүүс юу мэдэрсэн тухай тунгаан бод.

АСУУДАЛ 2

Яагаад би гэм нүглээ хүлээн зөвшөөрөх ёстой юм бэ? Яагаад зарим нүглийг санваартны удирдагчид хүлээн зөвшөөрөх ёстой вэ?

Их Эзэн Алмад нүгэл үйлдсэн хүмүүс “таны [тэдний санваарын ?удирдагч Алма] болон миний [Их Эзэн] өмнө нүглээ наманчлах хэрэгтэй” (Мозая 26:29) хэмээн хэлсэн.

- Их Эзэн бидний нүглийг хэдийн мэддэг учраас бид Түүнд гэм нүглээ наманчлах нь яагаад чухал вэ? Энэ нь бидний амьдралыг хэрхэн адисалдаг вэ?

Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө товхимлыг болон Далын ерөнхий эрх мэдэлтэн асан, ахлагч Скотт Грөүгийн дараах мэдэгдлүүдийг уншаад, бид хэзээ, яагаад бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчийн өмнө нүглээ хүлээх ёстой тухай ойлголтыг хайж ол.



Бишоп тойргийнхоо гишүүд, тэр дундаа таны талаар Ариун Сүнснээс илчлэлт авах эрхтэй. . . . Тэр таны эцэг эх, бусад удирдагчийн өгөх боломжгүй

арга замаар наманчлалын үйл явцаар дамжуулан танд тусалж чадна.

[Хэрэв бид наманчлахгүй бол] Аврагчид ачааг тань авахыг зөвшөөрөхийн оронд нүглийн ачааг ганцаараа үүрдэг. (C. Scott Grow, “Why and What Do I Need to Confess to My Bishop?” *New Era*, Oct. 2013, 28–29)

- Санваарын удирдагчдаа наманчлах талаар санаа зовж буй хүнд энэ мэдэгдэл хэрхэн тусалж болох вэ?

АСУУДАЛ 3

Их Эзэнийг намайг өршөөнө гэхэд би дэндүү их нүгэл үйлдсэн.

- Их Эзэний Мозая 26:29–30 дээрх үг энэ асуудалд хэрхэн туслах вэ? (Та мөн дараахыг судалж болно 1 Тимот 1:15; 1 Иохан 1:9; эсвэл Сургаал ба Гэрээ 18:10–12; 58:42–43.)
- Аврагчийн тухай ямар судрын цэдэг наманчлахыг эрмэлздэг хүмүүсийн талаарх Түүний мэдрэмжийг болон уучлахад бэлэн байдгийг харуулдаг вэ?

АСУУДАЛ 4

Таны сонголт

Өөр нэг бодитой санаа зовоосон асуудлын талаар бодож үзэж эсвэл наманчлалын талаар хэн нэгнээс асууж болох юм. Судруудын удирдамж дээрх “Наманчлал”-ыг эсвэл “Хүлээн зөвшөөрөх” зэргийг судалж (scriptures.ChurchofJesusChrist.org), тусалж болох үнэнийг хайж ол. Та мөн сэдэвчилсэн удирдамжаас “Наманчлал” эсвэл “Хүлээн зөвшөөрөх”-тэй холбоотой судруудыг давтаж болно (ChurchofJesusChrist.org). *Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө* товхимол дахь “наманчлал”-ыг судалж, Их Эзэний талаар юу мэддэгээ тунгаан бодох нь тустай байж болох юм.

ЕСҮС ХРИСТИЙН

ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ